

1990 оны мал тооллого

I. Малчдын тоо, тэдний соёл, ахуйн байдал

I.1. Малчдын тоо, бүрэлдэхүүн. 1991 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн мал маллаж байгаа нийт 75 мянган өрхийн 147.5 мянган малчид ажиллаж байна. Малчин өрхийн тоо өмнөх оныхоос 5.7 мянгаар, малчдын тоо 8.9 хувь буюу 12.1 мянгаар нэмэгдэв. Баян-Өлгийгөөс бусад аймагт малчдын тоо нэмэгдсэний дотор Төв, Говь-Алтай, Архангай, Өвөрхангай, Ховд, Дундговь аймагт 11.8-15.9 хувь буюу 737-1958 хүнээр нэмэгджээ.

Малчдын бүрэлдэхүүн залуужиж байна. 1985 онд нийгмийн мал аж ахуйд ажиллаж байсан нийт малчдын 47.6 хувь нь 16-35 насны залуучууд байсан бол 1990 онд 55.7 хувьд хүрчээ. Хөвсгөл, Өмнөговь, Дорнод, Дундговь, Баянхонгор, Дорноговь аймагт малчдын 57.6-62.8 хувь нь 35 хүртлэх насны залуучууд байна. Харин Төв, Сэлэнгэ аймаг, Дархан, Эрдэнэт хотод малчдын эгнээнд залуучуудын эзлэх хувийн жин харцангуй бага байна.

Тэтгэвэрийн насны \ 55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй \ 5.9 мянган малчид ажиллаж байгаа нь нийт малчдын 4 хувийг эзлэж байна. Бусад аймгуудтай харьцуулахад Төв, Ховд, Говь-Алтай, Сэлэнгэ, Завхан аймагт тэтгэвэрийн насны малчид олон байна. \ Хүснэгт 1—2 \

1989 онд 2.6 мянган малчин тэтгэвэрт гарч байсан бол 1990 онд энэ тоо 5.1 мянга болж нэмэгдлээ.

Өрх, малчдын тоо, бүрэлдэхүүн

	1989	1990
Малчин өрх (мян)	69.0	74.7
Малчдын тоо (мян)	135.4	147.5
Насны бүрэлдэхүүн (хувиар)	100.0	100.0
Үүнээс: 16-35 насны	51.0	55.7
36-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	45.0	40.3
Тэтгэврийн насны	4.0	4.0

I. 2. Малчдын соёл, ахуйн зарим үзүүлэлт. Малчин өрхийн 15.0 хувь, мал аж ахуйн бригадын 55.8 хувь, хэсгийн 42.6 хувь нь цахилгаан гэрэлтэй болсон байна. Малчин өрх болон мал аж ахуйн бригадын цахилгаанжилт үндсэндээ 1989

оны түвшингээс нэмэгдсэнгүй. Сэлэнгэ, Дорноговь, Хэнтий, Төв, Дорнод, Сүхбаатар аймагт малчин өрхийн 23-34 хувь нь цахилгаан гэрэлтэй байхад Өвөрхангай, Архангай, Баянхонгор аймагт энэ үзүүлэлт дөнгөж 6.5-8.6 хувьтай байна.

Малчдын гэрийн 20.2 хувь буюу 15.1 мянган өрх гэрийн даавуу бүрээсгүй, 29.7 хувь буюу 22.2 мянга нь брезентэн бүрээсгүй байна. Өмнөх оныхтой харьцуулахад гэрийн даавуу болон брезентэн бүрээсний хангамж бүхэлдээ муудлаа. Ялангуяа Увс, Завхан, Архангай аймагт малчдын гэрийн 31.3-44.0 хувь нь даавуу болон брезентэн бүрээсгүй, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл аймагт малчин өрхийн 31.9-47.5 хувь нь брезентэн бүрээсгүй гэж бүртгэгдлээ.

Малчин өрхийн 16.8 хувь буюу 12.6 мянга нь радио хүлээн авагчгүй байгаагийн дотор Увс, Хөвсгөл аймагт дөрвөн өрх тутмын нэг нь, Завхан, Архангай, Баян-Өлгий аймагт таван өрх тутмын нэг нь радио хүлээн авагчгүй байна.

Улсын хэмжээгээр малчин өрхийн 21.8 хувь нь мотоциклтэй байгаагийн дотор Өмнөговь, Дорноговь, Дундговь аймагт гурван өрх тутмын нэг нь, харин Увс, Ховд аймагт 9-13 хувь нь мотоциклтэй ажээ. \ Хүснэгт 2-3 \

1.3. Мал аж ахуйн мэргэжилтний хүрэлцээ хангамж. Мал аж ахуйн үйлдвэрлэлд 868 бригад, 613 хэсэг, 45.6 суурь ажиллаж байна. Урьд оныхоос суурийн тоо 5 мянгаар, бригадын тоо 336-аар нэмэгдэж, хэсгийн тоо 442-оор цөөрчээ. Нэг суурьт дунджаар ногдох малын тоо 1989 оныхоос 41 толгойгоор цөөрч, одоо 567 толгой мал ногдож байна. Гэтэл Өвөрхангайд 745, Завханд 734, Дорнодод 738 толгой мал суурьт дунджаар ногдож байна. \ Хүснэгт 4 \

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бригад, хэсгийн дарга 1.2 мянга, малын эмч 1,5 мянга, мал зүйч 1.0 мянга, тоо бүртгэгч 0.9 мянга, нярав 1.0 мянга ажиллаж байна. 1989 оныхоос мал аж ахуйн бригад, хэсгийн малын эмч, мал зүйч нарын тоо 258-283-аар буурав.

Одоо улсын дунджаар мал аж ахуйн бригад хэсэгт байгаа малын нэг эмчид 16.7 мянга, мал зүйчид 27.0 мянган мал ногдож байна. Энэ нь 1989 оныхоос тус бүрт ногдох малын тоо 3-7 мянгаар ихэслээ.

Дундговь, Өвөрхангай, Архангай, Завхан, Ховд, Хөвсгөл аймагт нэг мал зүйчид ногдох малын тоо улсын дунджаас 3.7-8.9 мянгаар илүү байна.

Гэрээ түрээсээр ажиллагч малчин өрх. 1990 онд 38.8 мянган малчин өрхийн 80.5 мянган малчид аж ахуйтайгаа энгийн гэрээтэй ажиллаж байгаа нь 1989 оныхоос 28.8 хувь нэмэгджээ. Мал түрээслэн ажиллаж буй малчдын тоо 17.4 мянгад хүрч өмнөх оныхоос 1.7 дахин нэмэгдэв.

1990 онд нийт малчдын 54.6 хувь нь энгийн, 11.8 хувь нь түрээсийн гэрээтэй ажилласан байна. Баянхонгор аймгийн нийт малчдын гуравны нэг нь түрээсийн гэрээнд, үлдэх нь энгийн гэрээнд хамрагджээ. Хөвсгөл, Увс, Сүхбаатар, Өвөрхангай, Өмнөговь, Булган аймагт малчдын 60.7-78.9 хувь нь энгийн гэрээнд, Дархан хот, Сэлэнгэ аймагт малчдын 28.7-78.7 хувь нь түрээсийн гэрээтэй ажилласан байна. \ Хүснэгт-5 \

1989 онд энгийн гэрээгээр ажиллагчид шагналд 65.5 мянган том мал, 115.2 мянган төл мал авч байсан бол 1990 онд шагналд 121.5 мянган том мал, 130.4 мянган төл авчээ. \ Хүснэгт 5-7 \

II. МАЛЫН ТОО

2.1. Нийт малын тоо. 1990 оны эцэст 25.9 сая мал тоологдсон нь өмнөх оныхоос 1.2 сая, урьд таван жилийнхээс 3.4 саяар нэмэгдэж, тэмээнээс бусад төрөл дээр малын тоо өслөө. Малын тооны цэвэр өсөлтийг бүхэлд нь амины малын өсөлтөөр, төрлөөр нь авч үзвэл 80.6 хувь нь хонь, ямааны өсөлтөөр хангагдсан байна. Хөдөө аж ахуйн нэгдлийн малын тоо 1989 оныхоос 468.1 мянга, сангийн аж ахуйнх 56.2 мянган толгойгоор буурав. Амины аж ахуйн мал 1987 онд 254 мянгаар, 1988 онд 410, 1989 онд 924 мянгаар нэмэгдэж байснаа 1990 онд 1396.3 мянгаар өслөө.

Нийт малын тоо бодод шилжүүлснээр урьд оныхоос 344.3 мянга, 1985 оныхоос 1108.4 мянгаар өссөн байна. Дорноговь, Өмнөговь аймгаас бусад аймаг хот малаа 1989 оныхоос өсгөсний дотор Архангай, Булган, Сэлэнгэ Хөвсгөл, Хэнтий аймаг, Улаанбаатар, Эрдэнэт хот таван төрөл дээр нь өсгөв.

VIII таван жилд малаа хамгийн сайн өсгөсөн \ 20.7-25.6 хувиар \ нь Төв, Завхан, Сэлэнгэ, Архангай, Өвөрхангай, Хэнтий аймаг болов. Тэрчлэн Эрдэнэт, Улаанбаатар, Дархан хотын малын тоо 1.8-2 дахин өссөн байна. Өнгөрсөн таван жилд ганцхан Сүхбаатар аймаг малаа хорогдуулжээ. \ Хүснэгт 13-14 \

Нийт тэмээн сүргийн тоо урьд оныхоос 20.8 мянгаар буурсан нь Дорноговь, Өмнөговь аймагт 5.7-6.8 мянгаар, Дундговь, Увс, Говь-Алтай Дорнод аймагт 1.0-2.2 мянгаар тэмээгээ хорогдуулснаас гол нь шалтгаалав.

Эдгээр аймаг тэмээний зарлагыг ихэсгэсний дотор Дорноговь, Дорнод аймаг оны эхны тэмээний 10.4-10.8 хувийг зүй бусаар хорогдуулсан байна.

1990 онд 244 сум, 17 сангийн аж ахуй, 87 нэгдэл малаа урьд оныхоос нэмэгдүүлсний дотор 95 сум, 3 сангийн аж ахуй, 12 хөдөө аж ахуйн нэгдэл төрөл тус бүр дээр нь өсгөсөн байна.

Улсад нийт малын тоогоор болон хониор Завхан, адуугаар Төв аймаг, үхрээр Хөвсгөл, ямаагаар Баянхонгор, тэмээгээр Өмнөговь тэргүүн байранд орж байна. Дундговь аймгийн Эрдэнэдалай сум нийт малын тоо \ 232.4 мян \ -- гоор болон хонь \ 132.0 мян \, адуу \ 27.1 мян \ -гаар, Өмнөговийн Ханбогд сум тэмээ \ 19.1 мян \-гээр, Архангайн Хангай сум үхэр \ 31.0 мян \ -гээр, Өвөрхангайн Богд сум ямаа \ 72.7 \ -гаар тус тус тэргүүлж байна.

Нэгдлүүдээс хамгийн олон \164.7 мян.тол \ малтай нь Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын " Хөгжил " нэгдэл, хамгийн цөөн \ 15.6 мян.тол \ малтай нь Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын " Цог " нэгдэл юм.

Одоо дунджаар нэг нэгдэлд нийгмийн 59.5 мянга, сангийн аж ахуйд 27.3 мянган мал ногдож байгаа нь урьд оныхоос нэгдлийнх 1.8 мянгаар, сангийн аж ахуйнх 1.1 мянгаар буурав.

Нийгмийн малын тоо. Нийгмийн малын тоо сүүлийн жилүүдэд буурч байснаа 1989 онд 628 мянгаар өссөн боловч 1990 онд 17.6 сая болж 1989 оныхоос 214.3 мянгаар буурлаа. Нийгмийн малын тоо 1989 оныхоос 10 аймагт,

1985 оныхоос 8 аймагт буурав. Өмнөговь, Хөвсгөл, Баян-Өлгий, Дорноговь, Дорнод аймгийн нийгмийн мал өмнөх оныхоос 36-84 мянгаар цөөрчээ.

Нийт нийгмийн мал 68.1 хувийг эзлэж байгаа нь 1989 оныхоос 4.1 пунктээр доошилсон байна.

Нийгмийн малын 61.0 хувь энгийн гэрээнд, 11.3 хувь нь түрээсийн гэрээнд хамрагджээ.

Гэрээ, түрээсэнд Сүхбаатар, Увс, Завхан, Булган, Баянхонгор аймгийн нийгмийн малын 82.1-89.6 хувь нь хамрагдаад байна. \ Хүснэгт 17 \

Хувийн (амины) малын тоо. 1990 онд улсын хэмжээгээр аминдаа малтай 260.9 мянган өрх, гэр бүл байгаа нь өмнөх оныхоос 15.8 мянгаар нэмэгдсэн байна.

Эдгээр өрхийн ам бүлийн тоо урьд оныхоос 8.3 хувь буюу 91.4 мян.хүнээр нэмэгдэж 1.2 сая боллоо. Амины малын тоо 8.2 саяд хүрч урьд оныхоос 20.4 хувь буюу 1.4 сая, 1985 оныхоос 3.2 саяар өсөв. Бүх аймаг, хотод амины малын тоо урьд оныхоос болон 1985 оныхоос нэмэгджээ. 1989 онд амины мал бүх малын 27.8 хувийг эзлэж байсан бол 1990 онд 31.9 хувийг эзлэх болов. \ Хүснэгт 18,19 \

Амины малын нийт өсөлтийн гуравны хоёрыг сүргийн нөхөн үйлдвэрлэлийн өсөлтөөр, үлдэх хэсгийг нь нийгмийн малаас аминд шилжиж ирсэн өсөлтөөр хангасан байна. 1990 онд шилжилтийн хөдөлгөөнөөр нийгмийн аж ахуйгаас аминд 220.9 мян.мал, энгийн гэрээний шагналд 251.9 мян.мал, бүгд 472.8 мян.мал нэмэгдэж очсон нь амины малын нийт өсөлтийн 33.9 хувийг эзлэж байна.

Амины малын 77.6 хувь нь нэгдлийн гишүүдэд, 22.4 хувь нь ажилчин, албан хаагчдад ногдож байна. Тэмээний 16.4 хувь, адууны 49.0, үхрийн 51.2, хонины 24.4, ямааны 37.2 хувь нь аминд байна.

Аминд байгаа малын бүтцийг авч үзвэл хонь 44.7 хувь, ямаа 23.1 хувь, үхэр 17.7 хувь, адуу 13.4 хувь, Дорнод, Хэнтий, Төв, Сүхбаатар аймгийн амины нийт малын 19-21 хувь нь адуу, Сэлэнгэ, Дорнод, Хөвсгөл аймагт 27-33 хувийг үхэр эзлэж байна.

Нэгдлийн гишүүдийн 138.7 мянган өрхөд 6.4 сая амины мал тоологдсон нь урьд оныхоос малын тоо 846 мянгаар, өрхийн тоо 5.7 мянгаар нэмэгдэв. Нэгдлийн гишүүдийн амины мал бүх аймагт өслөө.

Улсын хэмжээгээр нэгдлийн гишүүн нэг өрхөд дунджаар 46 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 4 толгойгоор нэмэгдэв. Дорнод, Архангай, Булган, Хөвсгөл аймагт нэг өрхөд дунджаар 29-36 толгой мал ногдож байхад Дорноговь, Дундговь, Говь-Алтай, Өмнөговь аймагт 63-68 толгой мал ногдож байна. Говийн бүсийн аймгуудын өрхийн малд бог мал зонхилж байгаа бол хангайн аймгийнхад үхэр, адуу мэдэгдэхүйц байр суурьтай байгаа билээ.

Одоо нэгдлийн гишүүн нийт өрхийн дотор огт малгүй өрх 1.4 мянга, 10 хүртэл малтай 16.1 мянган өрх, 11-30 малтай өрх 40.8 мянга, 31-50 малтай өрх 32.1, 51-100 малтай өрх 38.5, 101-200 малтай өрх 10.7, 201-ээс дээш малтай өрх 0.5 мянга байна. 1989 онд нэгдлийн гишүүн малгүй өрх 1.8 мянга байсан юм. \ Хүснэгт 23,24 \

Нэгдлийн гишүүн аминдаа огт малгүй өрх 1.4 мянга байгаа бөгөөд эдгээрийн 60 гаруй хувь нь зөвхөн Хэнтий, Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Сүхбаатар, Төв аймагт байна. 10 хүртэл малтай өрх нийт өрхийн 11.5 хувийг эзлэж байгаа боловч малын дөнгөж 1.6 хувийг эзэлж, нэг өрхөд дунджаар 6.3 толгой мал ногдож байна. Өрхийн 80 шахам хувь, малын 75.4 хувь нь 11-100 толгой малтай өрхүүд юм.

Өрхийн 0.4 хувийг эзэлж байгаа 201-ээс дээш толгой амины малтай харьцангуй хамгийн чинээлэг нь болох 492 өрхийн 64.8 хувь нь Сүхбаатар, Дундговь, Төв, Өвөрхангай, Дорноговь, Булган аймагт байна.

Ажилчин, албан хаагчдын 122.2 мян.өрх, гэр бүлд 1.8 сая мал тоологдсон нь урьд оныхоос малын тоо 1.4 дахин буюу 549.9 мянга, өрхийн тоо 8.3 мянгаар нэмэгдлээ. Аминдаа талтай ажилчин, албан хаагчдын малын тоо Баянхонгороос бусад аймаг, хотод өсөв. Ажилчин, албан хаагчдын нэг өрхөд дунджаар 15 толгой мал ногдож байгаа нь урьд оныхоос 4-өөр нэмэгдэв.

Аминдаа малтай ажилчин, албан хаагчдын нийт өрхийн дотор 10 хүртэл малтай өрх 49.3 хувь, 11-20 малтай өрх 25.3 хувь, 21-30 малтай өрх 13.4 хувийг эзлэж байна. 51-ээс дээш малтай өрх нийт өрхийн 3.4 хувь, малын тооны 15 хувийг эзэлж байна. \ Хүснэгт 24,25 \

Урьд оныхоос 31-50 малтай өрхийн тоо 2.2 дахин, 51-ээс дээш малтай өрхийн тоо 3.4 дахин нэмэгдэв.

Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот болон аймгийн төвийн малтай ажилчин, албан хаагчдын өрхийн тоо 11.6 хувь, малынх нь тоо 50.4 хувиар өсч, нэг өрхөд дунджаар ногдох малын тоо 6.9 толгой байснаа 9.3 толгой болов.

Сум, хороо, орон нутгийн хотын дэвсгэрт суудаг малтай ажилчин; албан хаагчдын өрхийн тоо 5.0 хувь, малынх нь тоо 40.3 хувиар өсч, нэг өрхөд дунджаар ногдох малын тоо 13.7 толгой байснаа 18.3 толгой болов.

Хот болон аймгийн төвд оршин суудаг малтай ажилчин, албан хаагчдын өрхийн 70 шахам хувь, сум, хорооны дэвсгэр нутагт суудаг ажилчин, албан хаагчдын өрхийн 40 шахам хувь нь 10 хүртэл малтай өрх гэр бүл байна.

Гэвч тооллогын дүнгээс үзэхэд малтай ажилчин, албан хаагчдын өрхийн бүрэлдэхүүнд цөөн малтай өрхийн хувийн жин буурсан байна. Ноднин жил 8-16 малтай өрх нийт өрхийн 80 шахам хувийг эзлэж байсан бол 1990 онд 10-20 малтай өрх 75 хувийг эзлэх болов.

Хээлтэгч мал. 1990 оны эцэст 12043.4 мянган хээлтэгч мал тоологдсон нь 1985 оныхоос 1.0 саяар, 1989 оныхоос 5.5 хувь буюу 623.1 мянгаар нэмэгдэж, ингэнээс бусад төрөл дээр өсөв.

Өмнөговь, Дорнод, Сүхбаатар аймагт хээлтэгч малын тоо 1985 оныхоос 5-46 мянгаар буурчээ. \ Хүснэгт 26-28 \

Бүх хээлтэгч малын 72.4 хувь нь нийгмийн, 27.6 хувь нь амины аж ахуйд байгаагийн дотор ингэний 16.3 хувь, гүүний 47.4, үнээний 46.0, эм хонины 21.2, эм ямааны 35.8 хувь нь аминд байна.

Нийгмийн хээлтэгч мал 1989 оныхоос 37.1 мянгаар буурчээ. Ялангуяа Архангай, Баян-Өлгий, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл аймагт их хэмжээтэй \ 13.4-26.7 мянгаар \ буурав.

Нийгмийн хээлтэгч малын тоо 1985 оныхоос 352.5 мянгаар буурсны дотор Сүхбаатар, Хөвсгөл, Өмнөговь, Дорнод зэрэг аймагт 44.8-81.9 мянгаар буурчээ.

Амины аж ахуйн хээлтэгч малын тоо өмнөх оныхоос бүх төрөлд өсч нийт дүнгээр 660.2 мянгаар нэмэгдсэн байна.

Нийт сүрэгт хээлтэгч мал 46.6 хувь эзлэх болж урьд оныхоос 0.3 пунктээр нэмэгдэв.

1990 онд 2680.5 мянган хээлтэгч шинээр нас дэвшиж нэмэгдсэн нь нийт хээлтэгчийн 22.3 хувь болж байна.

1990 онд 450.6 мянган хээлтүүлэгч мал тоологдсон нь урьд оныхоос 6.6 мянгаар нэмэгдэв. Өнгөрсөн онд 31.9 мянган хээлтүүлэгч шинээр нэмж тавьсан боловч буур, бог малын хээлтүүлэгч дутагдалтай болж эхэллээ. Одоо нэг хээлтүүлэгчид дунджаар 34 ингэ, 32-33 эм хонь, эм ямаа ногдож байгаа нь үржлийн нормоос ингэ 9, эм хонь, эм ямаа 2-3 толгойгоор их байна.

Төл бойжилт. 1990 онд гарсан төлийн 94.5 хувь буюу 9.5 сая төл бойжуулав. Бойжсон нийт төлөөс 506.2 мянгыг улс, орон нутгийн бэлтгэлд, 115.7 мянгыг аж ахуйн дотоод хэрэгцээнд, 33.5 мянгыг каракуль арьсанд нядалжээ. Улс орон нутгийн бэлтгэлд хэрэглэсэн төлийн тоо 1989 оныхоос 30.7 хувь буюу 224 мянгаар буурсан байна.

1990 онд 100 эхээс бойжуулсан төлийн тоо өнгөрсөн таван жилд хамгийн олон төл авсан 1989 оныхоос төрөл тус бүр дээр буурсан хэдий ч 1981-1985 оны дундажтай зэрэгцүүлбэл ботгоноос бусад төлийн төрөлд 7-8 –аар их байна.

Завхан, Увс, Ховд аймаг 100 хээлтэгчээс 89-90 төл бойжуулсан амжилтаар хошуучиллаа. \ Хүснэгт 48,49 \

Амины 100 эх малаас бойжуулсан төлийн тоо ХАА-н нэгдлийнхээс 4-өөр, үүний дотор ботго 2, унага 21, тугал 25, хурга 3, ишиг 6-гаар тус тус илүү байна.

Том малын зүй бус хорогдол. 1990 оны эхний малын 2.7 хувь буюу 673.2 мянган том мал зүй бусаар хорогдсон нь 1989 оныхоос 162.9 мянга, 1986-1990 оны дунджаас 78.7 мянгаар буурсан байна.

Дорнод, Дорноговь, Өмнөговь, Хэнтий малын хорогдол харьцангуй их гарч оны эхний малынхаа 4.2-6.4 хувийг буюу 223.2 мянган том мал зүй бусаар хорогдуулсан нь улсын хэмжээний нийт хорогдлын гуравны нэг хувийг эзлэж байна.

Зүй бусаар хорогдсон том малын 43.9 хувь буюу 295.6 мянга нь өвчнөөр, 18.6 хувь буюу 125.1 мянга нь гэнэтийн аюулаар, 37.5 хувь буюу 252.5 мянга нь бусад шалтгаанаар хорогдов.

Сэлэнгэ, Булган, Төв, Баян-Өлгий, Увс, Хөвсгөл, Архангай аймгийн нийт хорогдсон том малын 54.0-75.7 хувь нь зөвхөн өвчнөөр хорогдсон байна. Дорноговь аймгийн нийт хорогдсон малын 38.1 хувь нь гэнэтийн аюулаар, Өмнөговь, Дундговь, Өвөрхангай, Ховд аймгийн нийт хорогдсон малын 53.4-59.3 хувь нь бусад \ малчны хариуцлагагүй гэх мэт \ шалтгаанаар хорогджээ.

1990 онд оны эхэнд байсан нийгмийн малын 3.5 хувь буюу 616.1 мянган мал хорогдсон нь амины аж ахуйгаас 2.7 пунктаар илүү байна.

Нийгмийн хорогдсон малын 44.4 хувь нь өвчнөөр, 18.9 хувь нь гэнэтийн аюулаалаар, 36.7 хувь нь бусад шалтгаанаар хорогдов. Өвчнөөр хорогдсон нийгмийн мал аминыхаас 5.5 пунктаар их, бусад шалтгаанаар хорогдсон мал 9.6 пунктаар бага байна.

Том малын хорогдол сангийн аж ахуйд, тэр тусмаа өвчнөөр хорогдох явдал харьцангуй их гардаг нь хэвээр байна.

1990 онд 347.8 мянган хээлтэгч мал зүй бусаар хорогдсон нь оны эхний эх малын 3.3 хувь, том малын зүй бус хорогдлын 38.5 хувийг эзлэж байна. Баян-Өлгий, Говь-Алтай, Сүхбаатар, Сэлэнгэ, Дорнод, Хэнтий аймагт нийт хорогдсон малын 40.3-49.3 хувийг хээлтэгч малын хорогдол эзлэж байна. \ Хүснэгт 56-57 \

Малын хээл хаялт, сувайралт. 1990 оны эхний хээлтэгч малын 10.5 хувь буюу 1196.0 мянга нь сувайрсан \ 7.4 хувь \, хээл хаясан \ 3.1 хувь \ шалтгаанаар төл өгөөгүй нь 1989 оныхоос 16.8 хувь буюу 172.1 мянгаар их байна.

Төл өгөөгүй эх малын 70 хувь нь буюу 840.8 мянга нь сувайрч, 30 хувь нь буюу 352.2 мянга нь хээл хаясан байна.

Хэнтий, Архангай, Дорнод, Өмнөговь, Төв, Булган, Дорноговь, Сэлэнгэ аймагт эх малын хээл хаялт, сувайралт харьцангуй их гарч оны эхний эх малын 11.4-20.3 хувьд хүрчээ.

Малын төрлөөр авч үзвэл гүү, үнээний сувайралт, хээл хаялт \ оны эхний малын 26-35 хувь \, бусад малынхаас харьцангуй их, унага, тугал бойжуулах ихээхэн нөөц алдаж байна. \ Хүснэгт 58-62 \

Дөрвөн төрлийн хорогдол. 1990 онд төл, том малын хорогдол, хээл хаясан сувайрсан мал 2428.9 мянгад хүрсэн нь 1989 оныхоос 26.4 хувь буюу 507.4 мянгаар ихэссэн байна. Дөрвөн төрлийн хорогдол зөвхөн Ховд, Увс, Хөвсгөл, Баянхонгор аймагт 1989 оныхоос буурав. \ Хүснэгт 63-64 \

Малын хэрэглээний зарлага. 1990 онд малын нийт зарлага 7574.9 мянга байгаа нь 1989 оныхоос 5.0 хувь буюу 362.0 мянгаар ихсэв.

Оны эхний малд малын нийт зарлага 30.7 хувь, үүний дотор улс, орон нутгийн бэлтгэлд 15.6, хүнсэнд хэрэглэсэн мал 12.4, малын зүй бусын хорогдол 2.7 хувийг тус тус эзлэж байна.

Том малын нийт зарлагад улс, орон нутгийн бэлтгэл 50.8 хувь, хүнсэнд хэрэглэсэн мал 40.3, зүй бус хорогдол 8.9 хувийг эзлэж байна. Малын нийт зарлага Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Сүхбаатар аймагт оны эхны малынх нь 33.0-35.0 хувьд хүрсэн байхад Төв, Сэлэнгэ, Архангай аймагт 26.6-28.5 хувь байна. \ Хүснэгт 65 \

Сүргийн бүтэц. 1990 онд нийт сүргийн дотор бог мал 78.1 хувийг, үхэр 11.0, адуу 8.8, тэмээ 2.1 хувь эзлэж байгаа нь үндсэндээ өмнөх оныхоо түвшинд байна. Харин тэмээний тоо 20.8 мянгаар хорогдсонтой холбогдон сүрэгт эзлэх хувийн жин нь 0.2 пунктаар буурав. Одоо нийт малын 68.1 хувь, тэмээний 83.6, адууний 51.0, үхрийн 48.8, хонины 75.6, ямааны 62.8 хувь нь нийгмийн аж ахуйд байна.

1989 оныхоос нийт малд нийгмийн малын эзлэх хувь 4.2 пунктаар, тэмээ 2.0, адуу 3.4, үхэр 2.9, хонь 4.0, ямаа 6.0 пунктаар тус тус буурчээ.

VIII таван жилд манай улсын малын сүргийн бүтэц сайжрах хандлагатай болсон байна. 195 онд нийт сүрэгт төл, хээлтэгч мал 82.3 хувь, эр сувай мал 11.5 хувийг эзлэж байсан бол 1990 онд төл, хээлтэгч мал 80.5 хувь, эр сувай мал 13.0 хувийг эзлэх болов. Энэ хугацаанд төл, хээлтэгч, хээлтүүлэгчээс бусад малын тоо 1.0 саяар, үүний дотор эр сувай мал 774 мянган толгойгоор нэмэгдсэн байна. Ялангуяа амины аж ахуйд эдгээр малын тоо 1.5 дахин өсчээ. \ Хүснэгт 69-70 \

Бэлтгэлийн насны эр мал. 1990 оны эцэст бэлтгэлийн насны 2361.6 мянган эр мал тоологдсоны дотор эр үхэр 243.7, эр хонь 1286.4, эр ямаа 831.8 мянга байна. Энэ нь өмнөх оныхоос нийтдээ 21.7 хувь буюу 421.5 мянгаар, үүний дотор үхэр 33.7 мянга, хонь 291.4 мянга, ямаа 96.4 мянгаар нэмэгдэв.

Аймгууд дотроос Өвөрхангай, Өмнөговь, Завхан аймаг бэлтгэлийн насны эр малын нөөцөөр илүү байна. Харин Сэлэнгэ, Сүхбаатар, Төв, Дундговь, Дорнод аймагт бэлтгэлийн эр үхрийн нөөц харьцангуй бага юм.

Улсын хэмжээгээр бэлтгэлийн насны эр хонь сүрэгт 8.5 хувийг эзэлж байхад Дархан, Эрдэнэт, Улаанбаатар хотод 14.4-21.9 хувийг эзлэж байна.

Ажлын мал. 1990 онд ажил, эдэлгээний 130.0 мянган ат, 595.9 мянган морь, 32.1 мянган шар байгаа нь өмнөх оныхоос ат 4.4 мянгаар буурч, морь 5.3 мянга, шар 1.4 мянгаар нэмэгдэв. Улсын хэмжээгээр атны 60.0 хувь, морины 76.6, шарны 13.2 хувийг ердийн хөсөгт ашиглаж байна. \ Хүснэгт 74 \

Ердийн хөсгийн ашиглалтад өмнөх оныхоос ахиц гарсангүй.

II.2. Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал. 1990 оны эцэст цэвэр үүлдрийн 506.0 мянга, эрлийз 1345.3 мянга, нутгийн шилдэг омгийн 1240.9 мянган мал тоологдсон нь өмнөх оныхоос цэвэр үүлдрийн мал 30.6 мянга, нутгийн шилдэг омгийн мал 67.6 мянгаар нэмэгдэж, эрлийз мал 197.9 мянгаар цөөрлөө.

\ Хүснэгт 75-76 \

Цэвэр үүлдрийн үхрийн тоо Завхан, Хэнтий аймаг, Улаанбаатар хотын аж ахуйнуудад, хонь Өвөрхангай, Сэлэнгэ, Архангай, Булган аймагт, ямаа Өмнөговь, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай аймагт урьд оныхоос буурчээ.

1990 онд тоологдсон нийт үхрийн 8.9 хувь, хонины 7.8 хувь, ямааны 8.3 хувийг цэвэр, эрлийз мал эзлэж байна. Нийт цэвэр эрлийз үхрийн 45.8, хонины 47.5, ямааны 7.2 хувь нь сангийн аж ахуйд байна.

1990 оны эцэст цэвэр үүлдрийн болон эрлийз 958.6 мянган хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оныхоос 68.2 мянгаар буурсны дотор эм ямаа 29.2, эм хонь 43.3 мянгаар цөөрчээ.

Харин цэвэр, эрлийз үнээ 4.2 мянгаар өсөв.

Нийт цэвэр, эрлийз малд үнээ 44.6, эм хонь 53.6, эм ямаа 51.2 хувийг эзлэж байна.

IV. Тэжээвэр амьтад.

1990 оны эцэст 134.7 мянган гахай, 326.2 мянган шувуу, туулай 7.2, үнэг 1.3, булга 9.7 мянга тоологдов. 1989 оныхоос гахайн тоо 57.5 мянга, шувууны тоо 43.8 мянга, туулай 4.8 мянгаар буурсан байна.

Аж ахуйн бүх салбарт гахай, шувууны тоо өмнөх оныхоос их хэмжээтэй цөөрчээ. Баян-Өлгийгөөс бусад аймаг, хотод гахайн тоо, Баян-Өлгий, Төв, Булган, Ховд аймгаас бусад аймаг, хотод шувууны тоог хорогдуулсан байна. Гахайны зарлага нэмэгдэж, дэгдээхэй бойжуулалт муу, сүрэг сэлбэлт хангалтгүй байгаа нь тоо толгой буурах үндсэн шалтгаан болов.

1990 оны эцэст 19.7 мянган үндсэн мэгж, 199.2 мянган өндөглөгч тахиа тоологдсон нь 1989 оныхоос мэгжийн тоо 22.7 хувь, өндөглөгч тахианы тоо 16.3 хувь буурав.

Тоологдсон нийт гахайн 66.6 хувь, мэгжний 71.5 хувь нь амины аж ахуйд, гахайн 18.9 хувь, мэгжийн 11.6 хувь нь сангийн аж ахуй, тэжээлийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдэлд байна.

Нийт гахайн үндсэн мэгжийн тоо 14.7 хувь, шувууны 62.4 хувийг өндөглөгч эзэлж байна.

1990 онд 100.8 мянган торой, 351.0 мянган дэгдээхэй бойжуулсан нь 1989 оныхоос торой 48.2 мянгаар, бойжуулсан дэгдээхэй 103.3 мянгаар буурсан байна.

Улсын төвлөрсөн болон аж ахуйн дотоод хэрэгцээнд 110 мянган гахай, 92.6 мянган шувуу хэрэглэсэн нь 1989 оныхоос гахай 12.5 мянгаар нэмэгдэж, шувуу 206 мянгаар бага байна.

1990 онд улсын хэмжээгээр 173 хөдөө аж ахуйн нэгдэл, нэгдэл дундын үйлдвэр, хоршоолол, 53 сангийн аж ахуй, тэжээлийн аж ахуй, 619 албан газар, 15.7 мянган айл өрх гахай, 69 хөдөө аж ахуйн нэгдэл, нэгдэл дундын үйлдвэр, хоршоолол, 23 сангийн аж ахуй, тэжээлийн аж ахуй 58 албан газар, 1.3 мянган айл өрх шувуу өсгөн үржүүлж байна.

* * * * *

Малчдын тоо 1985 оныхоос 14.1 мянган хүнээр нэмэгдэж, бүрэлдэхүүн нь залуужив. Энэ хугацаанд аминдаа малтай өрх, гэр бүлийн тоо 38.7 мянгаар нэмэгдсэн байна.

VIII таван жилд дунджаар жилд 9 саяас доошгүй төл бойжуулах зорилт хангагдаж, нийт болон хээлтэгч мал өсгөх төлөвлөгөө давж биелэгдэв. Мал сүргийн тоо сүүлийн гучаад жилд анх удаа 25 саяас давж өссөн нь малыг гэрээ, түрээсээр ажиллах хэлбэрээр эзэнд нь ойртуулсан, нөгөө талаас амины малын тоонд хязгаарлалт тогтоохгүй болсон, экспортод гаргах мал, махыг нилээд багасгасан зэрэг төр, засгаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, малчин түмний нөр их хөдөлмөр, зүтгэлийн үр дүн боллоо.

Өнгөрсөн таван жилд мал аж ахуйн үйлдвэрлэлийн өмчийн харьцаанд мэдэгдэхүйц өөрчлөлт гарлаа. 1985 онд манай улсын таван мал тутмын нэг нь амины аж ахуйн мал байсан бол 1990 онд гурван малын нэг нь аминых болов.

Сүргийн бүтэц сайжирч, эр сувай малын хувийн жин нэмэгдлээ.

Мал тооллоготой хамтруулан авсан малчдын нийгэм ахуйн зарим үзүүлэлтийн судалгаанаас үзэхэд малчдын ажиллаж амьдрах нөгцөлд төв, орон нутгаас илүү анхаармаар байна. Улсын хэмжээгээр малчин өрхийн цахилгаанжилтын түвшинд ахиц гарсангүй.

- Ялангуяа Өвөрхангай, Архангай, Баянхонгор аймагт малчдын цахилгаанжилтыг дээшлүүлэхэд онцгой анхаарах.
- Малчдын гэрийн даавуу болон брезентен бүрээсний хангамж сайжруулах талаар Архангай, Увс, Завхан, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл аймаг зориуд арга хэмжээ авах.
- Дундговь, Өвөрхангай, Архангай, Завхан, Ховд, Хөвсгөл аймагт нэг мал зүйчид ногдох малын тоо ихээхэн нэмэгдсэнд анхаарч дүгнэлт хийх.
- Олон жил мал малласан туршлагатай малчдыг тэтгэвэрт гарахад нь аль болохоор суурь, хот айлд зөвлөгчөөр ажиллуулах.
- Орон нутагт ердийн хөсөг ашиглалтыг өргөжүүлэхэд чиглэсэн тодорхой ажлыг урамшуулалтай холбон зохион байгуулах.

- Өнгөрсөн таван жилд манай улсын тэмээн сүргийн тоо 21.5 мянга буюу хамгийн олон тэмээтэй Ханбогд сумын тэмээнээс ч олон тоотой хорогдлоо. Энэ байдалд шууд нөлөөлсөн Өмнөговь, Дорноговь, Баянхонгор, Сүхбаатар, Дорнод аймагт тэмээ өсгөх талаар 1988 оны 6 дугаар тогтоолын заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН

ГАЗРЫН ДАРГА.....Б.ЦЭНД-АЮУШ

1991 – 03 - 15